

“ШУУД АРДЧИЛАЛ ИРГЭДИЙН ОРОЛЦОО” ХӨТӨЛБӨР

Үндэслэл:

Монгол Улсын Үндсэн хуулийн гуравдугаар зүйлд “Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ” гэж заасан байдаг.

Төрийн болон нутгийн өөрийн удирдах байгууллагууд орон нутгийн түвшинд шийдвэр гаргахдаа иргэдийг оролцуулах, тэдний саналыг бодлогод тусгах, гүйцэтгэлийг ил тод тайлагнах, нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж хэвшүүлэх, нийтийн зар мэдээг хүргэх, олон нийтийн санал асуулга явуулах, “Иргэний танхим”-уудыг байгуулж үйл ажиллагааг нь тогтмолжуулан чадваржуулах зэргээр шинэтгэлийн олон алхмуудыг орон нутагт эхлүүлэх, эрчимжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Бодлогын шинэтгэлийн хүрээнд “Шууд ардчилал иргэний оролцоогоор дамжуулан төвлөрлийг сааруулах үндэсний дунд болон урт хугацааны бодлогын баримт бичиг”-ийг 2012 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 176 дугаар зарлигаар баталсан төдийгүй 2013 оныг “Шууд ардчилал-иргэний оролцооны жил” болгох тухай энэ оны эхний зарлигаа гаргалаа.

2013 оны 01 дүгээр сарын 01-нээс мөрдөж эхэлсэн “Төсвийн тухай” хуульд Монгол Улсын Ерөнхийлөгчийн зүгээс орон нутгийн төсөвт иргэдийн оролцоог хангах талаар бие даасан бүлэг, зүйл, заалт оруулсан нь төсвийн менежментэд иргэдийн оролцоог баталгаажуулсан эрх зүйн томоохон шинэтгэл боллоо.

Монгол Улсын түүхэнд нийгмийн материаллаг баялгийн хуваарилалт, түүний зарцуулалтад иргэдийг оролцуулах эрх зүйн зохицуулалтыг Төсвийн тухай хуулийн шинэтгэлээр эхлүүлсэн нь урд өмнө огт байгаагүй цоо шинэ үйл явц юм. Тус хуулиар орон нутаг төсвийн тодорхой эрх мэдэлтэй болж байгаа бөгөөд нутгийн захиргаа баг, хорооны иргэдээсээ санал асууж хамгийн их санал авсан асуудалд хөрөнгө, мөнгөө хуваарилдаг зарчимд шилжиж байна.

Төсвийн тухай хуулинд туссан иргэдийн оролцооны шинэ үзэл баримтлалыг хэрхэн яаж бодит ажил хэрэг болгох вэ гэсэн асуултыг иргэд маань тавьж байна. Төсвийн төвлөрлийг сааруулахад иргэдийн оролцоог хангах чиглэлээр нийтэд ойлгомжтой, цэгцтэй бодлого, арга механизм үгүйлэгдэж байна.

Зорилго:

Шийдвэр гаргахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, төрийн үйл ажиллагааг иргэдэд нээлттэй, ил тод болгож хариуцлага, тайлагналын механизмыг төлөвшүүлэхэд төрийн албан хаагчдын үүрэг оролцоог нэмэгдүүлэх.

Зорилт:

Ардчиллын чанар, төрийн үйл ажиллагааны зарчим, төрийн албан хаагчийн ёс зүйн талаарх иргэд, иргэдийн төлөөлөгчид, төрийн албан хаагчдын ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх. Шийдвэр гаргахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, төрийн үйл ажиллагааны ил тод байдал, хариуцлага тайлагналын механизм бий болгох зарим арга замыг тодорхойлох.

Хамрах хүрээ:

Иргэд, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчид, багийн Иргэдийн Нийтийн Хурлын дарга, Засаг даргын Тамгын газар, төсвийн байгууллагын ажилтнуудын дунд зохион байгуулна.

Хугацаа:

Аймгийн ИТХ-ын Ажлын албаны Олон нийттэй харилцах хэлтэс. 2014 онд

Хүрэх үр дүн:

Иргэд, төрийн албан хаагчдын Шууд-Ардчилал, Иргэдийн оролцооны талаарх мэдлэг нэмэгдэж төрийн бодлого шийдвэрт иргэд өөрсдийн санаа бодлыг тусгах боломж бүрдэнэ.

НЭГ: ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ ЧИГЛЭЛЭЭР

Багийн иргэдийн нийтийн хурал болон Иргэний танхимийн хэлэлцүүлэгт Шууд ардчилал иргэдийн оролцоо, чиглүүлэгчийн сургалтуудыг явуулах.

1.1. Сургалтын чиглэл

Мэдээлэл: Шууд ардчилал гэж юу вэ? Иргэдийн оролцоо, төрийн хариуцлагатай байдал, харилцан тайлагналын талаар.

Багийн ажил: Чиглүүлэгч багаар ажиллах талаар доорх зааварчилгаа өгнө.

- Бүлгийн гишүүн бүр саналаа хэлэх
- Гарсан саналуудыг багцлах, ач холбогдлоор нь дугаарлах
- Сонгох асуудлууд дээр тогтож ярилцах
- Сонгож авсан асуудлууд дээр ярилцаж, гарах арга замын хувилбарыг тодорхойлно.

Сургалтанд оролцогчдын тооноос хамааран 5 бүлэг буюу 10-12 хүний бүрэлдэхүүнтэй баг болгож хувиарлана.

Даалгаврыг танилцуулна: Багууд доорх сэдвүүдээс сонгож авч, бодит байдалд үнэлэлт өгч, гарах арга замыг тодорхойлно.

- Шийдвэр гаргахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх боломж
- Төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх арга зам
- ИТХ-ын төлөөлөгчид иргэдийнхээ өмнө үйл ажиллагаагаа тайлагнадаг уу
- Иргэдийн төлөөлөгчдийн хурлыг нээлттэй болгох зорилтыг хэрэгжүүлэхэд таны санал
- Төлөөллийн хариуцлага тайлагналыг нэмэгдүүлэх арга зам
- Иргэний өргөдөл гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх зарчмыг боловсронгуй болгох арга зам
- Баг хорооны Иргэдийн нийтийн хурлын чадавхийг дээшлүүлэх боломж арга зам
- Сум дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын үйл ажиллагааг сайжруулах арга зам

Багуудын үйл ажиллагаа:

- Багууд өгөгдсөн сэдвээр даалгавар дээр хамтран ажиллана.
- Чиглүүлэгч ажиллах явцад нь зөвлөгөө өгөх, шаардлагатай бол чиглүүлэх асуулт тавих, санал хэлэх зэргээр дэмжлэг үзүүлнэ.

Багуудын мэдээлэл, ярилцлага:

Чиглүүлэгчийн тарааж өгсөн цаасан самбарт даарах байдлаар багийн ажлын үр дүнгээ бичиж танилцуулна.

Багийн нэр:

Даалгаврын агуулга: Шийдвэр гаргахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх боломжийг тодорхойлох

| Шийдвэр гаргах иргэдийн оролцоо /өнөөгийн байдал/ | | Шийдвэр гаргахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх боломж | |
|---|----------------------|---|----------------------|
| Багийн гишүүдээс гарсан саналууд | Багийн нэгдсэн санал | Багийн гишүүдээс гарсан саналууд | Багийн нэгдсэн санал |
| 1. | 1. | 1. | 1. |
| 2. | 2. | 2. | 2. |
| 3. | 3. | 3. | 3. |
| 4. | 4. | 4. | 4. |
| 5. | | | |

- Баг тус бүр ажлынхаа үр дүнг танилцуулна.
- Багууд өөр бусад багуудын ажил дээр санал дүгнэлт хэлэх, асуулт тавих зэргээр харилцан ярилцана.
- Чиглүүлэгч багуудын ажлыг нэгтгэн дүгнэх, эсвэл оролцогчдоос нэгдсэн дүгнэлт гаргуулна.

1.2 Иргэний танхимын хэлэлцүүлэг.

Дараах саналуудыг үндэслэн хэлэлцүүлгүүдийг зохион байгуулна. Хэлэлцүүлгээс гарсан санал, шүүмжлэлийг холбогдох газруудад нь уламжлах, шаардлагатай тохиолдолд мэргэжлийн чиглэлийн хүмүүсийг оролцуулах болон судлуулах, ажлын хэсэг байгуулах арга хэмжээг зохион байгуулна.

- Сургалтаас гарсан Иргэдийн санал хүсэлтийг үндэслэн хэлэлцүүлэг зохион байгуулах.
- Судалгааны дүнд үндэслэн хэлэлцүүлэг зохион байгуулах
- 70431111 утсаар иргэдээс ирсэн саналыг үндэслэн хэлэлцүүлэг зохион байгуулах.
- Иргэд Иргэний танхимд биеэр ирж хэлэлцүүлэг зохион байгуулах саналаа ирүүлсэн хүсэлтийг үндэслэнэ.
- Байгууллагуудын саналыг үндэслэн тулгамдсан асуудлаар хэлэлцүүлэг зохион байгуулна.

1.3. Орон нутгийн “Эко” телевизтэй хамтран “Шууд ардчилал-иргэдийн оролцоо-Мэдээлэл” цуврал хичээлийг 3 дугаар болгон иргэдэд хүргэнэ. Мөн иргэдээс өгсөн саналыг үндэслэн ИТХ-ын төлөөлөгчид, албан байгууллагууд, удирдлагуудыг оролцуулан “Нээлттэй яриа нэвтрүүлэг” зохион байгуулна.

1.4. ИТХ-ын khovd.khural.mn болон Facebook, Twitter хуудсуудаар дамжуулан иргэдэд мэдээлэл өгөхөөс гадна иргэдийн дунд тулгамдсан асуудлаар санал асуулга тогтмол хугацаанд зохион байгуулна.

ХОЁР: ТУРШЛАГА СУДЛАХ ЧИГЛЭЛЭЭР

- 2.1. Ерөнхийлөгчийн иргэний танхимтай танилцаж туршлага судлах.
- 2.2. Шууд ардчилал хүрээлэнгийн ажилтай танилцаж туршлага судлах
- 2.3. Хан-Уул, Чингэлтэй дүүргийн Иргэний танхимтай танилцаж туршлага судлах, Удирдлагын академи болон Шууд ардчиллын чиглэлээр сургалт зохион байгуулах
 - Иргэний танхим нь сайн ажиллаж байгаа аймаг, дүүргийн туршлага судлах
 - Гадаад орны туршлага судлах
 - Туршлага судлах сургалтууд

ГУРАВ: СУДАЛГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

Иргэдээс нийгэм улс төрийн санаа бодлын давтамжит судалгаа авах. /2 удаа тус бүр 250 иргэнээс авна./

ДӨРӨВ: ИРГЭНИЙ ТАНХИМЫГ ТОХИЖУУЛАХ

Сандал ширээ хуучирсан, эвдэрсэн, шинэ мэдээллийн самбарууд хийх, зөөврийн аппортур узель шинээр авах шаардлагатай байгаа болно.

ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

- Шууд Ардчилал Иргэдийн оролцоогоор дамжуулан төвлөрлийг сааруулах дунд болон болон урт хугацааны бодлогын баримт бичиг /2012-2022/ 176-р зарлиг
- Монгол улсын Үндсэн хууль
- Төсвийн тухай хууль /2011.12.23/
- Төрийн албаны тухай хууль

- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирголоос урьдчилан сэргийлэх тухай хууль /2012.01.19/
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль /2011.06.16/
- “Ардчилал Монгол улсад” лекц /УТБА-ын сургалтын хэрэглэгдэхүүн. 2008 он/
- Д.Ганбат. Ардчиллах үйл явц ба монголчуудын үнэлэмж. Шинэ толь № 61.
- Ардчилал Монгол улсад лекц. /УТБА-ын лекц 2008/Доржжав. Д. Удирдахуйд суралцахуй., Сонгодог жишээн дээр. УБ., 2002

“Шууд Ардчилал- Иргэдийн оролцоо” хөтөлбөрийн
тойм

| № | Үйл ажиллагааны нэр | Хариуцах эзэн | Шалгуур үзүүлэлт | Арга |
|---|--|---|--|---|
| 1 | Иргэд болон төрийн албан хаагчдад иргэний танхимын талаар мэдлэг олгох | Иргэний танхим | Төр, хувийн хэвшил, баг бүрийн төлөөлөл оролцсон уулзалт ярилцлага зохион байгуулна | Танилцуулга бэлдэх |
| 2 | Иргэний танхимаар хэлэлцүүлэх ажил, асуудлын календарчилсан төлөвлөгөөтэй болж түүнд хяналт тавих ажлын хэсгийг бий болгох | Иргэний танхимын зөвлөлийн гишүүд, Орон нутгийн төрийн байгууллага, иргэд | Хэлэлцүүлэх ажлын календарчилсан төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавих ажлын хэсэг бий болгох | Уулзалт хийх |
| 3 | Төлөвлөгөөний дагуу хэлэлцүүлэг зохион байгуулах | Иргэний танхим, Орон нутгийн төрийн байгууллага, хувийн хэвшил, иргэд | Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэдэд таниулан сурталчилснаар иргэдийн оролцоо нэмэгдсэн байна. Мөн Иргэний танхимын ач холбогдол болон танхимын талаар мэдлэг мэдээлэлтэй болсон байх | ТВ нэвтрүүлэг болон сонинд нийтлэл гаргах |
| 4 | Хэлэлцүүлгийн дагуу холбогдох байгууллагуудад бичиг хүргүүлэх, хэлэлцүүлгээс гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх | Иргэний танхим хариуцсан мэргэжилтнүүд | Хэлэлцүүлгийн үр дүнд хийгдсэн ажлууд | Шийдвэр, тогтоол, албан бичиг болон хариу үйлдлээр тодорхойлогдоно. |
| 5 | Иргэний танхим | Туршлага | Иргэний танхимаар хэлэлцүүлж зохион байгуулсан төлөвлөгөөний | Иргэний танхим хариуцсан ажилтны ажлын |

| | | | | |
|---|--|---|---|------------------------------------|
| | хариуцсан ажилтныг чадавхижуулах | судлуулах, сургалтанд хамруулах | биелэлтийг тооцож улирал бүр ажлын хэсэг, ИТХ-ын Тэргүүлэгчид, орон нутгийн хэвлэл мэдээлэл, иргэдэд нээлттэйгээр мэдээлж хэвшсэн байх. | улирлын тайлан, тэмдэглэл |
| 6 | Хөтөлбөрийн эцсийн үр дүнг танилцуулах | ИТХ-ын Тэргүүлэгчид, Төлөөлөгчид, ТББ-ууд | Иргэний танхим байнгын үйл ажиллагаатай болж шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоо нэмэгдэнэ. Иргэний танхимын үйл ажиллагаа тогтворжсон байна. | Хөтөлбөрийн үйл ажиллагааны тайлан |

-----000-----